



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/71

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрд сумын нутаг дэвсгэрт дэх “Тарнын гүүрний хяналтын цэг”-т ажиллах албан хаагчдын үйл ажиллагаа, илүү цагийн урамшуулалд шаардагдах зардал 12,768,500 (арван хоёр сая долоон зуун жаран найман мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Хяналтын постонд ажиллах албан хаагчдын ажил үүргийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг хангуулах, зохион байгуулалтын арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100138

Аймгийн Засаг даргын 2021 оны...
 дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр
 захирамжийн хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ТАРНЫ ПОСТЫН ЗАРДЛЫН НЭМЭЛТ ТООЦОО

1. Тарны постыг 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдөр хүртэл ажиллана
2. Тус постонд ЭМГ 1, үйлчилгээний ажилтан 1, цэргийн алба дүйцүүлэн хаах албан хаагч 1 нэмэгдэж, нийт 11 албан хаагч ажиллана.

№	Шаардагдах хэрэгсэл	Тоо, хэмжээ /ширхэг /	Нэг бүрийн үнэ, мян/төг/	Нийт үнэ / мян/төг	Тайлбар
2. Үйл ажиллагааны зардал					
1	Хоол	31 хоног /3хүн/	15,000	1,350,000	
2	Хоол	5 хоног /19хүн/	15,000	1,425,000	
2	Хог хадгалах сав	3 ш/ төмөр /	30,000	90,000	
3	Албан хаагчдын машинд бензин	1 хоногт-30л/31 хоног /	1,500	1,395,000	
4	Бичиг хэрэг	баталгааны хуудас, тараах материал	200,000	200,000	
5	Холбооны зардал	гэр интернет, утасны эрх сунгуулах	200,000	200,000	
6	Хогийн сав/гишгэдэг/	4	20,000	80,000	
7	Ус буцалгагч, баллонтой ус /	2	100,000	200,000	
8		НИЙТ		4,940,000	
9	Цэвэрлэгээний материал	гарын цаасан салфетка 20*6500	6,500	130,000	
		Близна 5*3000	3,000	15,000	
		угаалгын нунтаг 3кг 2*20000	20,000	40,000	
		Хувин 2*6000 /жижиг/	6,000	12,000	
		шалны хувин 1*10000	10,000	10,000	
		шалны мод 1*10000	10,000	10,000	
		хогийн шүүр 1*20000	20,000	20,000	
		цэвэрлэгээний алчуур 8*8000	8,000	64,000	
		барааны саван 10*1200	1,200	12,000	
		3 өнгө алчуур 2ш	5,500	11,000	
		хогийн уут 5ш	5,500	27,500	
		дардаг сав 4*2500	2,500	10,000	
		Цэвэрлэгээний хувин 2ш /том/	8,000	16,000	
		НИЙТ		377,500	